



БАЯНХОНГОР АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН  
ХУРЛЫН ТОГТООЛ

2018 оны 10 сарын 05 өдөр

Дугаар 112

Номгон

Дуудлагын худалдаа зохион байгуулах  
тов тогтоох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 зүйлийн 18.1.3-ын “а”, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.3, Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын ээлжит бус XIII хуралдааны 13/03 дугаар тогтоолыг тус тус үндэслэн аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Аймгийн Орон нутгийн өмчийн газар, Баянговь сумын Засаг даргын Тамгын газар, Соёлын төв, Богд сумын Засаг даргын Тамгын газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй барилгуудын дуудлагын худалдааг холбогдох хууль журмын дагуу 2018 оны 11 дүгээр сарын 09-ний өдрийн 11.00 цагт аймгийн Засаг даргын Тамгын газрын 103 тоот өрөөнд зохион байгуулж, орлогыг аймгийн Орон нутгийн өмчийн газрын Төрийн сан банкин дахь 100030051006 тоот дансанд төвлөрүүлсүгэй.

2. Худалдсан хөрөнгийн хөдлөл өөрчлөлтийг зохих журмын дагуу хийхийг аймгийн Орон нутгийн өмчийн газрын дарга /Ц.Идэрмөнх/-д даалгасугай.

3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн даргын үүрэг гүйцэтгэгч /Т.Эрдэнэбат/-д үүрэг болгосугай.

ДАРГА



Ц.ОТГОНБАЯР